



Цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчийн гарын авлага

“Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК

НЭР ТОМЬЁО

ТАЙЛБАР

1. **"Цахим мөнгө хүлээн авагч" цаашид ЦМХА** гэж ББСБ-тай гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж, цахим мөнгийг төлбөрт хүлээн авч, өөрийн бараа, үйлчилгээг борлуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг;
2. **"Бүртгэлгүй хэрэглэгч"** гэж ББСБ-тай гэрээ байгуулахгүйгээр доорх хязгаарын дотор цахим мөнгөний үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээдийг;
 - Нэг өдрийн гүйлгээний дээд хязгаар 20,000 төгрөг;
 - Цахим дансны дээд үлдэгдэл 100,000 төгрөг;
3. **"Хэрэглэгч"** гэж ББСБ-тай гэрээ байгуулж доорх хязгаарын дотор цахим мөнгөний үйлчилгээ авах иргэн, хуулийн этгээдийг;
 - Нэг удаагийн гүйлгээний дээд хязгаар 1,000,000 төгрөг;
 - Нэг өдрийн гүйлгээний дээд хязгаар 3,000,000 төгрөг;
 - Цахим дансны дээд үлдэгдэл 50,000,000 төгрөг
4. **"Төлөөлөгч"** гэж ББСБ-тай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний нэрийн өмнөөс шинэ хэрэглэгчийн бүртгэл, цахим мөнгөний үйлчилгээг гүйцэтгэх болон өөрийн цахим мөнгөний гүйлгээг хийх хуулийн этгээдийг;
5. **"Дансны дугаар"** гэж цахим мөнгөний үйлчилгээнд оролцогчдын гар утасны дугаар, эсхүл ББСБ-ын программ хангамжид автомат системээр дугаарлагдаж, оролцогчид оноогдсон дахин давтагдашгүй дугаарыг;
6. **"Цахим мөнгөний үйлчилгээний гэрээ"** гэж Хэрэглэгч болон ББСБ-ын хооронд байгуулагдах Цахим төлбөр тооцооны үйлчилгээний гэрээг;
7. **"Үйлчилгээний салбар"** гэж харилцагч, хэрэглэгчдэд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг тайлбарлан таниулах, гэрээ байгуулах, гэрээ цуцлах зэрэг үйлчилгээг үзүүлэх ББСБ-ын үйлчилгээний төвийг;
8. **"Цахим мөнгө"** гэж цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгчээс нэхэмжилж болохуйц, төлбөр тооцоонд ашиглагдах бүрэн боломжтой, төгрөгийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдэх мөнгөний үнэ цэнтэй зүйлийг ойлгох ба тусгай зориулалтын цахим төхөөрөмжид байрлах, бэлэн мөнгөнд чөлөөтэй хөрвөх, мөнгөн хадгаламж, татан төвлөрүүлсэн хөрөнгө гэж үзэхгүй, түүнд хүү бодогдохгүй мөнгөн хөрөнгийг;
9. **"Баталгааны данс"** гэж ББСБ нь цахим мөнгөнд хөрвүүлсэн оролцогчийн мөнгөн хөрөнгийг 100% (хувь) баталагаа болгон харилцагч банкны баталгааны дансанд байршуулсан харилцах дансыг;
10. **"Цахим данс"** гэж аппликейшн дахь цахим мөнгийг агуулж буй дансыг;
11. **"Цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч"** гэж ББСБ-ыг;
12. **"Цахим мөнгөний үйлчилгээнд оролцогч"** эсхүл **"Оролцогч"** гэж ББСБ, Хэрэглэгч, Төлөөлөгч, ЦМХА-ийг;

АППЛИКЕЙШН СУУЛГАХ ЗААВАР



App Store

- App Store-д нэвтрэн хайх хэсэгт **netapp** эсвэл **netappmn** гэж бичиж хайна.

- **Get** товч дээр дарснаар меню сууна



Google Play


- Play Store-д нэвтрэн хайх хэсэгт **netapp** эсвэл **netappmn** гэж бичиж хайна.

- **Install** товч дээр дарснаар меню сууна

Гар утсанд тавигдах шаардлага:

- IOS 9.0-аас дээш, Андроид 2.1-ээс дээш үйлдлийн системтэй байх;
- Mobile Network тохиргоо хийсэн байх эсвэл Wi-Fi-аар интернэтэд холбогдсон байх.

НЭВТРЭХ ЗААВАР



● Хэл солих

Нэвтрэхдээ..

● Бүртгэлтэй гар утасны дугаар, нууц үг ашиглан үндсэн цэсрүү нэвтэрнэ.


● Намайг санах дээр дарж нэвтрэх гар утасны дугаараа сануулах боломжтой

● Хурууны хээ болон нүүр таних биометрик тохиргоогоор нэвтрэх боломжтой.

● Нэвтрэх нууц үгээ мартсан бол энд дарж сэргээх боломжтой.

● Шинэ хэрэглэгч бол энд дарж бүртгүүлнэ.

ШИНЭЭР БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР



1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

Аппликейшн ашиглахтай холбоотой үйлчилгээний нөхцөлийг сайтар уншиж танилцана уу.

Уншиж танилцаад зөвшөөрч байвал **Зөвшөөрч байна** товчин дээр дарж бүртгэлээ үргэлжлүүлнэ.

ШИНЭЭР БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР

12:22

Бүртгэл 2/2

mongolia -аар бүртгүүлэх

Е-Mongolia системээр бүртгүүлбэл гэрээ байгуулахгүйгээр 100'000₮ хүртэлх дижитал зээл авах боломжтой.

эсвэл

Утасны дугаар

8*3* 8**2 ✓

Регистрийн дугаар

1А 0000 0000

Овог

Нэр

Бүртгүүлэх

2. E-Mongolia эсвэл гараас бүрэн мэдээллээ оруулан бүртгүүлнэ.




Аюулгүй байдлын үүднээс системээс нэг удаагийн нэвтрэх нууц үг илгээнэ.

Шаардлагатай мэдээллүүд:

- Гар утасны дугаар/ТАН кодоор батаглаажуулна/, Регистрийн дугаар, Овог, Нэр, Амьдардаг дүүрэг, тухайн үеийн цээж зураг/selfie/

ХЭТЭВЧ ЦЭС ЗААВАР




● Хэтэвчний үлдэгдэл харах ба нүдний icop дээр дарж үлдэгдлээ нуух боломжтой.

● Хэтэвчээ цэнэглэх, Мөнгө шилжүүлэх, QR уншуулан төлбөр тооцоо хийх боломжтой.

● Ойрийн хугацаанд идэвхтэй байгаа хямдрал, урамшууллаудыг харах боломжтой.

● Гүйлгээний хуулга харах боломжтой.




МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ЗААВАР


Мөнгө шилжүүлэх дараах боломжуудаас сонгоно.

- Өөрийн данс хооронд
- Нэткапиталын дотоодын дансруу
- Гар утасны дугаараар
- Гүйлгээний загвар дуудах боломжуудтай
- Банкны дансруу
- Өөрийн картруу


БАНКНЫ ДАНСРУУ МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ




1. Хүлээн авагчийн дансны
мэдээллийг оруулаад
үргэлжлүүлнэ.



Хүлээн авагчийн банк сонгох



Гүйлгээний төрөл солих



БАНКНЫ ДАНСРУУ МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ

2. Шилжүүлэх дүн, гүйлгээний утгыг оруулна.

*Гүйлгээний утга заавал оруулах шаардлагагүй.

1	2	3
4	5	6
7	8	9
	0	

ПИН кодоо мартсан?

3. Гүйлгээний пин код оруулна.


Гүйлгээ амжилттай

Голомт банкны 1105677128 данс руу
6'000.00₮ шилжүүллээ.

OK

[Гүйлгээний загварт хадгалах](#)

Гүйлгээ амжилттай болсон
мэдэгдэл гар утсан дээр
харагдана



БАНКНЫ ДАНСРУУ МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ

2. Шилжүүлэх дүн, гүйлгээний утгыг оруулна.

*Гүйлгээний утга заавал оруулах шаардлагагүй.

1	2	3
4	5	6
7	8	9
	0	

ПИН кодоо мартсан?

3. Гүйлгээний пин код оруулна.

Гүйлгээ амжилттай

Голомт банкны 1105677128 данс руу
6'000.00₮ шилжүүллээ.




OK

[Гүйлгээний загварт хадгалах](#)


Гүйлгээ амжилттай болсон
мэдэгдэл гар утсан дээр
харагдана

ӨӨРИЙН ДАНСРУУ МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ

1. Хүлээн авах данс, шилжүүлэх данс, гүйлгээний дүн, утгыг оруулаад үргэлжлүүлнэ.




2. Гүйлгээний пин код оруулна.



Гүйлгээ амжилттай болсон мэдэгдэл гар утсан дээр харагдана

УТАСНЫ ДУГААРААР МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ



1. Хүлээн авагчийн утасны дугаар, дүн, утгыг хийж үргэлжлүүлнэ.

Санамж: Хүлээн авагч нэткапиталын депозит данстай байх шаардлагатай.

1	2	3
4	5	6
7	8	9
	0	

ПИН кодоо мартсан?

2. Гүйлгээний пин код оруулна.

Гүйлгээ амжилттай


Голомт банкны 1105677128 данс руу
6'000.00₮ шилжүүллээ.

OK

[Гүйлгээний загварт хадгалах](#)


Гүйлгээ амжилттай болсон мэдэгдэл гар утсан дээр харагдана

QR УНШУУЛЖ ТӨЛБӨР ТӨЛӨХ



1. Мерчантын QR кодыг уншуулна.

QR УНШУУЛЖ ТӨЛБӨР ТӨЛӨХ



2. Шилжүүлэх дүн, шижлүүлэг хийх өөрийн дансыг сонгоно.

Санамж: Хүлээн авагч нэткапиталын мерчант байгууллага байх шаардлагатай.

1	2	3
4	5	6
7	8	9
	0	

ПИН кодоо мартсан?

3. Гүйлгээний пин код оруулна.


Гүйлгээ амжилттай

Голомт банкны 1105677128 данс руу
6'000.00₮ шилжүүлээ.

OK


[Гүйлгээний загварт хадгалах](#)

Гүйлгээ амжилттай болсон
мэдэгдэл гар утсан дээр
харагдана




ХЭТЭВЧ ЦЭНЭГЛЭХ ЗААВАР

1. **Хэтэвч** цэсний **данс цэнэглэх** хэсэгт дарна.




2. Цэнэглэх дансаа сонгоно.

ХЭТЭВЧ ЦЭНЭГЛЭХ ЗААВАР




1. Зээлээр цэнэглэх

Дижитал зээлийн нөхцөлтэй танилцаж өөрт тохирох нөхцөлөөр зээл авч цэнэглэх боломжтой.



2. QRay цэнэглэх


Qray үйлчилгээгээр дурын банкны аппликейшнээр цэнэглэх боломжтой.



3. Банкны дансаар


Интернэт банк ашиглан дансруу гүйлгээ хийх боломжтой.

ХУУЛГА ХАРАХ ЗААВАР




1. **Хэтэвч** цэсний сүүлд хийсэн гүйлгээнүүд хэсэгт дарж дансны хуулгаруу орно.

ХУУЛГА ХАРАХ ЗААВАР



2. Дансны хуулга хэсэгт хэрэглэгчийн хийсэн бүх төрлийн орлого, зарлагын мэдээлэл харагдана



Дансны хуулгыг огноогоор шүүж харах боложмтой.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

Үйлчилгээний нөхцөл	Цахим төлбөр тооцооны бүртгэлгүй хэрэглэгчийн дүнтэй гүйлгээний эрх	Цахим төлбөр тооцооны гэрээ байгуулсан хэрэглэгчийн гүйлгээний эрх
Netwallet хэтэвчийн дансны үлдэгдлийн дээд хязгаар	100,000 /нэг зуун мянга/ төгрөг	50,000,000 /тавин сая/ төгрөг,
Netwallet хэтэвчээр хийх нэг удаагийн гүйлгээний дээд хязгаар	20,000 /хорин мянга/ төгрөг	1,000,000 /нэг сая/ төгрөг
Netwallet хэтэвчээр хийх өдрийн гүйлгээний дээд хязгаар	20,000 /хорин мянга/ төгрөг	3,000,000 /гурван сая/ төгрөг байна.

ШИМТГЭЛ, ХУРААМЖИЙН НӨХЦӨЛ

Гүйлгээний төрөл	Гүйлгээний зорилго, давтамж	Шимтгэл
Цахим дансанд мөнгө хүлээн авах	Мөнгөн хөрөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэн цахим хэтэвчид хийх бүрд	0₮
Хэрэглэгчрүү цахим мөнгө шилжүүлэх	Цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлэн цахим хэтэвчнээс гаргах бүрд	0₮
Цахим дансаас Нэткапитал ББСБ-н зээл төлөх	Цахим хэтэвчийн зээлийн төлбөр төлөх бүрд	0₮
Төлбөр төлөх	Гэрээт мерчант байгууллагаас худалдан авсан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлбөр төлөх бүрд	0₮
Өөрийн болон бусдын банкны дансруу цахим данснаас мөнгө шилжүүлэх	Цахим хэтэвчийн данснаас Банкны данс руу шилжүүлэх бүрд	100₮ - 500₮ /Төлбөр хүлээн авагч банкнаас хамаарна/
Хуулга харах болон үлдэгдэл шалгах	Цахим хэтэвчийн дансны хуулга харах, үлдэгдэл шалгах бүрд	0₮
Тодорхойлолт	Цахим хэтэвчийн дансны орлого, зарлагын гүйлгээний мэдээ хийх бүрд	1500₮
Орлогын гүйлгээ	Мөнгөн хөрөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэн цахим хэтэвчид хийх бүрд	Төлөөлөгчөөр дамжуулахад 500₮
Зарлагын гүйлгээ	Цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлэн цахим хэтэвчнээс гаргах бүрд	Төлөөлөгчөөр дамжуулахад 500₮